



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР**

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-мэйл: khuvs gul-tender@khs.gov.mn
Вэбсайт: <http://umch.khs.gov.mn>

2025.1.30 № 1/35
танай _____-ны № _____-т

**ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛД**

Чиглэл хүргүүлэх тухай

Орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн Удирдах Зөвлөлд дараах чиглэлийг хүргүүлж байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2024 оны 12 дугаар сарын 12-нд орсон өөрчлөлтийн дагуу тус хуулийн 21, 21.1 дүгээр зүйлийн 21,13 дахь заалтыг хэрэгжүүлж www.shilen.gov.mn мэдээллийн сайтад компанийн мэдээллийг байршуулж улирал бүр үнэлгээ дүгнэлт авч байх;
2. Орон нутгийн өмчит компаниудын гүйцэтгэх захирал нартай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г байгуулж, дүгнэх;
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх, 2025 оны бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн III/21 дүгээр тогтоолоор баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд үндэслэн батлах, бизнес төлөвлөгөө батлахдаа урд оны үлдэгдлийг зарцуулах эрхийг хамт батлах;
4. Орон нутгийн өмчит компаниудын үйл ажиллагааны орлогыг үр ашигтай төлөвлөж зарцуулах, маркетингийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, зардлыг хэмжээг үе шаттай бууруулах, орлого болон ашгийн түвшнийг нэмэгдүүлэх зарчмаар бодлого боловсруулах, бизнес төлөвлөгөөг бодитой үндэслэлтэй төлөвлөхөд анхаарах;
5. Компаниас олон нийтэд үзүүлж байгаа үйлдвэр үйлчилгээний тарифын тооцооллыг нягталж, төлбөр тариф батлах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах. Манай байгууллагад санал хүсэлтээ ирүүлэх. Ялангуяа хог хаягдал зайлуулах, бохир ус зайлуулах, төв суурины гэрэлтүүлэг, камержуулалтын арчлалтын өртөг тодорхой бус байгаагаас компанид ачаалал үүсэж болзошгүй тул ажил үйлчилгээ бүрийг өөрийн өртөг тооцоололд тулгуурлаж гэрээ байгуулж ажиллах.
6. Машин механизм, тоног төхөөрөмжийг бусад этгээдэд ашиглуулахдаа ажилласан цаг, элэгдэл хорогдол зардалд суурилсан төлбөр тарифыг баталж компанид орлогыг төвлөрүүлэх

7. Компанийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлд GPS төхөөрөмж суурилуулж бүтээмжийг хянах тогтолцоог бүрдүүлэх;
8. Компанийн засаглалыг сайжруулах, орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн Удирдах зөвлөлийн аудитын хорооны гишүүд тухайн байгууллагын ажлын явцын хяналт, шалгалтыг дотоод хяналтын ажилтантай хамтран улирал бүр хийж, анхаарах асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд танилцуулан, гарсан алдаа дутагдлыг арилгах арга хэмжээг авч хагас жилийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлж байх;
9. Орон нутгийн өмчит компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөний хүлээгдэж буй гүйцэтгэлийг сараар гаргуулж дараа сарын 05-ны өдрийн дотор хүлээн авах, улирал бүрийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг дараа сарын 10-ны дотор, хагас жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг 07 дугаар сарын 20-ний өдрийн дотор, жилийн эцсийн гүйцэтгэлийг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлж байх;
10. 2025 оны 05 дугаар сарын 01-ээс өмнө Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн үйл ажиллагааны тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулж шийдвэр гаргуулах;
11. Орон нутгийн өмчит компанийн орон нутгийн өмчид ногдох ногдол ашгийн хэмжээг тогтоох, орон нутгийн орлогод төвлөрүүлэх;
12. Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ийн хурлыг сар бүр хуралдуулж гишүүдийн цалинг үр дүнг тооцон олгох талаар санаачлагатай ажиллах;
13. Компанийн санхүү төсөв үйлдвэрлэлийн мэдээллийг сар бүр гаргуулж өмчлөгчийн эрх хэрэгжүүлэгч нарыг хангах (аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, орон нутгийн өмчийн газарт)

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлж хамтран ажиллана уу. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байх чиглэлийг манай байгууллагад ирүүлсэн тул аймаг сумын ИТХ-д манай байгууллагаас дүгнэлтээ 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлж ажиллана.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БЭХБАЯР

